

## ӨВӨР МОНГОЛООР ЯВСАН ТЭМДЭГЛЭЛ

М. ЗЭНЭЭ

1985 оны 12-р сард БНХАУ-ын Өвөр Монголын өөртөө засах орны (ӨМӨЗО) Хөх хот дахь урлагийн «Улаан мөчир» чуулгын жүжигчид манай улсад айлчлан тоглох үеэр Өвөр монголын алдарт дуучин, төрийн шагналт Лхасүрэнтэй танилцах завшаан надад тохиолдсон юм. Бид хоёр уулзаад нэр нэрээ хэлж, гараа бариуаа л бие биеэ таниж билээ. Учир нь миний бие урьд нь алдарт дуучин М. Лхасүрэн, түүний гэргий Төмөрцэцэг (Чжоу Биньцзян) хоёрын талаар «Дорнодахины судлалын асуудал» сэтгүүлд (1984, 1985 оны дугааруудад) хоёр ч удаа бичиж байсан юм. Тэр удаагийн учирлаас хойш бид захиа би чилцэн ажил, амьдралынхаа тухай харилцан сонирхоцгоож, байнгын холбоо харилцаатай байв. Төмөрцэцэг (Чжоу Биньцзян) бол Өвөр Монголын Нийгмийн Шинжлэх Ухааны хүрээлэнгийн Монгол утга зохиол судлах газрын<sup>1</sup> орлогч захирлаар ажилладаг хүн, Лхасүрэн, Төмөрцэцэг нарын урилгаар БНХАУ-д очиж Хөх хот болон Бээжин бусад газруудаар явж үзсэн харсан зүйлээсээ цувруулан бичиж уншигчдад товч боловч танилцуулахаар эхний хэсгийг толилуулж байна.

### 1. ЗАМД ТӨРСӨН СЭТГЭГДЭЛ

Цагаан өмсгөлөөр битүү хучигдсан эх орныхоо тал нутгийг галт тэрэгний цонхоор ажиг явсаар нэг өдрийг өнгөрөөж маргааш өглөө нь буюу 1987 оны 2 дугаар сарын 25-ны 10 цаг 45 минутанд БНХАУ-ын хилийн боомт Эрээн хотод галт тэргээр хүрч очиход барилга-байшингийн нь гэрэл чимэглэлээс аваад гудамжны нь цементэн цардмал хүртэл цан хүүрэгт цавцайн цайгаад наранд гялтганан гялалзаж байв. Сүүлийн хэдэн жилд нүүр царайгаа өөрчилж, өдөр ирэхүйяа тохижин томорсоор байгаа тэр хотод 10 мянгаад хүн оршин суудаг ажээ. Эрээн хот БНХАУ-ыг БНМАУ, ЗХУ болон баруун Европын улс орнуудтай ган замаар холбож, гар атгуулан уулзуулж байсан түүхтэй боловч «соёлын хувьсгал» гэгчээс болж сүүлийн 20 жилд анхаарлын гадна орхигдож олигтой дэвжихгүй байсаар 1980 оны дунд үеэс л өөрчлөлт орж эхэлсэн гэнэ. 1984 оны 9-р сард ХКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга агсан Ху Яобан (ХАЧА-ийн Бээжингийн цэргийн тойргийн командлагч Цзин Зивэйтэй хамт) Өвөр Монголд ирж Цзинин-Эрээний төмөр замын дагуу аялан Шилийн гол аймаг, Сөнөд баруун хошуу, Эрээн хотоор бууж саатсан ажээ. Ху Жобан Эрээн хотод ирээд «өмнө талд Шэньчжэнь<sup>2</sup> байна. Умар талд Эрээн байна гэж бодогдтол тохижуул» гэж хэлсэн хэмээн тухайн үед хэвлэлд тэмдэглэж байсан билээ. Иймээс хотыг тохижуулах ажил сүүлийн жилүүдэд ид өрнөж байна. Хүмүүсийн яриаг сонсвол Ху Яобан «... ах дүү нар чинь хилийн цаана байна. Аль болох өргөн харил-

1 Газар гэдэг нь манай хүрээлэнтэй адил. ӨМӨЗО бол Хятадын хувьд засаг захиргааны нэгж учраас бүх зүйл нь нэг шат доошилж нэрлэгдэнэ.

2 Гуандун мужид гадаадын хорвонгө оруулалтаар сүүлийн үед барьсан том хотыг Шэньчжэнь гэж нэрлэнэ.

цаж, Эрээн хотыг хойд зүгийн нээлттэй хот болго» гэсэн гэнэ. Мөн Нэг удаа «монгол үндэстний онцлогтой урлагаа хөгжүүлэх талаар яагаад анхаарахгүй байна» гэж нэлээд ноцтой анхааруулга өгсөн гэж ч ярилцаж байхыг сонслоо. Эрээн хотоор одоо жилд 20 мянган жуулчид өнгөрч байна гэсэн тоо хэвлэлд тэмдэглэгдэж байна.

«Хэрэлдэж байхаар хэлэлцэж суу» гэсэн сайхан үг монголчуудын дотор байдаг. Хоёр улсын харилцаа зөөлөрч, олон талаар өргөжвөл сайнсан гэж Эрээн хотын галт тэрэгний өртөөний үйлчлэгч нартай ярилцахдаа би хэлсэнд тэд энэ тун үнэн үг шүү» хэмээн их л баяртай дэмжиж, танилцахыг хүсч байсан нь өмнөх харилцааны буруу арга барилаас халширсан байдлыг харуулж байлаа. Эрээн хотын орчим усгүй цэвэр шүү, давс, цахиур чулуу, хайлуур жонш, байгалийн хий, нефть олзворлох үйлдвэр байдаг юм байна. Эндээс эртний үлэг гүрвэлийн яс нэг биш удаа малтан гаргасан билээ. 1979 оны 8-р сард 80 метр гүнээс аварга гүрвэлийн чулуужсан бүтэн яс малтан гаргасан байна<sup>3</sup>. Иймээс энд малталт хийх судлаачид шил шилээ даран цувдаг болоод удаж байна. Мөн хими, үндэсний хувцас, арьс шир боловсруулах зэрэг шинэ үйлдвэр ч байна. Хотын гудамж талбай нь цэвэр, мод тарих ажилд их анхаарч буй нь ажиглагдлаа. Гудамж тал байгаар хувиараа засвар үйлчилгээ эрхэлж байгаа хүмүүс суучихсан гутал тахалж, унадаг дугуй засварлаж мөнгө олж байх юм. Энэ хотод гуанз, дэлгүүр, сургууль соёлын газар, засаг захиргааны болоод галт тэрэгний үйлчилгээний төвөөс гадна гадаад тээврийг хариуцах алба, ургамал-амьтны хорио цээрийн алба, эмнэлгийн урьдчилан сэргийлэх үзлэгийн алба, хилийн гаалийн хороо, ардын цэргийн хамгаалалтын алба зэрэг энгийн хотод огт байдаггүй өвөрмөц албан газрууд байдаг. 1985 онд телевизийн өндөр цамхагийг ашиглалтанд оруулсан бөгөөд эргэн тойрон 50 км газар долгион цацах чадалтай болохоор 4 км зайтай байдаг манай Замын Үүдэд ямар ч саадгүй нэвтрүүлэг гарч байдаг юм. Монгол, Хятад хоёр улсын хилийн боомт энэ хотоор 7 хоногт 3 удаа өнгөрдөг олон улсын галт тэрэг Эрээнд хэдэн цаг амсхийдэг нь «бусдаас өвөрмөц төмөр замын шугамд нь таарсан дугуй сольж» байгаа нь тэр ажээ. Дугуй сольсоны дараа бид Эрээн хотын эелдэг ааштай үйлчлэгч нартай гар дохин салах ёс гүйцэтгээд хөдөлж билээ.

300 км урт Эрээн-Цзинины замд гарч Шилийн гол аймгийн Сай хан талаар явахад өвс, ногоо шарлан халиурсан, үржил шимтэй чий гэрхэг хөрс малын бэлчээрт их л тохиромжтой мэт үзэгдэнэ. Тэнд сүүлийн хэдэн жилд амьдрал нэг үеэ бодвол дээшилж байна гэж хү мүүс ярьж байна. Шилийн голын хөвөөт шар хошууны жилийн орлого 1978 онд 1 сая 930 мянган юань болж хүн бүрд 123 юань оног дож байсан бол 1985 онд 7 сая 960 мянган юань болж нэг хүнд 533 юань хүрч<sup>4</sup> 7 жилийн дотор 4 дахин өсчээ. Хөлсний хүн зарах явдал Шилийн голын өмнөд хошуугаар тун ихэсчээ. Ийм ажил эхлээд удаа гүй боловч Тайфуши, Шулуун цагаан, Хөвөөт шар, Сөнөд баруун хо шуу зэргээр нэлээд өргөжин зарим суманд бараг хоёр өрхөд 1 хөлс ний хүн оногдох болжээ<sup>5</sup>. Хэбэй, Шаньси, Улаанцаваас ирсэн тариа чид ийм хөлсний хүмүүс болон хувирч байна. Ажилтай ба «ажил хү-

3 «Өвөр Монголын эмэгтэйчүүд сэтгүүл, Хөх хот, 1982. № 7, 62-р тал

4 «Өвөр Монголын залуучууд сэтгүүл, Хөх хот, 1986, № 19, 13-р тал

5 «Өвөр Монголын залуучууд Хөх хот, 1986. No 22. 16-р тал

лээсэн хүмүүсийн» зохицуулах эл аргыг дээрээс их дэмжиж, өөрчлөлт хийхэд олон бэрхшээл, шийдвэрлэх асуудал тулгарна. Шийдвэрлээд өөрчлөнө гэвэл «үхсэн махан дээр ачаа ачсантай адил»<sup>6</sup> гэж хэвлэлд тэмдэглэж байгаа учир «өөрчлөлтийн явц дунд амьдрал, практик дээр шийдвэрлэх» гэгч өнөөдөр зонхилох арга болж байна. Хятад улсад ажил хүлээгсэд хэдэн 10 саяар яригдаж байгаа бөгөөд 1 миллиард 60 сая гаруй хүн амыг ажил амьдралаар хангана гэдэг амар асуудал бишээ. Гэхдээ махаар талонгүй хангах байдалд ороод байгаа нь нэлээд ажил хийж байгааг харуулж байна.

2-р сарын 25-ны орой 20 цаг 20 минутанд Улаанцав аймгийн Цзинин хотод хүрч очиход галт тэрэгний өртөөн дээр алдарт дуучин Лхасүрэн гэргийнхээ өгсөн баглаа цэцгийг барин угтсанаар БНХАУ-д байх 20 гаруй хоног минь эхэлж билээ. «Хаалттай хот» Цзининд гадаадын зочныг угтан авч, хожим буцахад нь тэнд амруулаад үдэж мордуулсан нь Лхасүрэнгийн урлагт амьдралаа зориулсан олон жилийн хөдөлмөрийн алдар, түүний гэргий (БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн ерөнхий сайд агсан Чжоу Энълайн өргөмөл охин Чжоу Биньцзян буюу) Төмөрцэцэгийн монголчуудын дотор олсон нэр хүндтэй<sup>7</sup> холбоотой байсан биз. Ямар ч байсан энэ хоёр хүн нам, засгийн ивээл, ард түмний итгэлд түшиж явдаг улс болох нь харагдаж байсан. Лхасүрэнтэй хамт Өвөр Монголын Их сургуулийн багш Мандах гэж нас тогтсон зузаан бор эр ирсэн нь түүнийг дээд боловсрол эзэмшүүлж, хөлийг нь дөрөөнд, гарыг нь ганзганд хүргэж өгсөн БНМАУ-аас ирэх зочиноос сонин сонсох, ах дүү нарыхаа тухай асууж сонирхох, нөхөртөө туслах сэтгэл дийлснийх байсан биз. «Дөрвийн бүлгийн хорлол» улс орныг цусан далайд живүүлж байсан хүнд үед «Ар Монголын тагнуул» нэртэй хэлмэгдэж байсан энэ хүн 1960 онд МУИС-төгссөн бөгөөд өнөөдөр тайван байдалд ажил амьдралаа зохицуулж яваа нь Хятадын байдалд «өөрчлөлт гарч байгааг харуулна. «Төрийн нуруу төвшин бол түмэн олонд зовлонгүй» гэдэг ардын сайхан үг бий. Хардлага, хавчилга, мөрдөлт, мөшгөлт явагдаж байсан өмнөх 20 гаруй жилийн харгис байдалд өөрчлөлт орсон болохоор хүмүүсийн өнгө зүс, өмсөх зүүх, үг ярилцах, хүн хүндэтгэх байдалд нь хүртэл өөрчлөлт орж «гадаадынханд нээлттэй» байлгах төрийн бодлогод сэтгэл нь уужирсан «хаалттай хотын» үйлчлэгчид хүртэл цаанаа нэг айх эмээх явдал нь арилсан мэт уужуу тайван байдлаар бидэнтэй ярьсан нь «өөрчлөлт газар авч байна» гэсэн бодол төрүүлсэн. Хэдхэн жилийн өмнө 1977 онд Америкийн нэрт монголч эрдэмтэн О. Латтимор Өвөр Монголын нутгаар дайрч ирэхдээ «хүнтэй санасан бодсоноо ярих монгол хүн алга болжээ» хэмээн гайхаж байсныг тодхон санаж байна.

Цзинин бол 200-гаад мянган хүнтэй, аж үйлдвэр, төмөр замын (зорчигч ба ачаа тээврийн хот бөгөөд арьс шир, нэхмэл зэрэг улсын чанартай 70-аад үйлдвэр, 300 гаруй гар үйлдвэрт 100 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Бээжинд ч, Хөх хотод ч хаана ч гэсэн «ажил хүлээсэн хүмүүсээ ажилтай болгохын тулд хувийн дэлгүүр, гуанз, байгуулах, засварын газар нээх, гар үйлдвэр эрхлэж бүтээгдэхүүнээ зах зээл дээр чөлөөтэй борлуулахыг уриалж, хийлгэж байна. Зах зээлийг хөөр хөгжөөнтэй болгож байгаа тухай хэвлэлд бичээд байдаг нь энэ ажээ. Хөдөөгийн малчид хот суурин бараадаж,

6 Мөн тэнд

7 Энэ талаар дараа бичих цуврал дээр тодорхой баримтаар хөндөх болно.

хувийн ажил эрхлэх явдал ч их гарч байна. «30 настай Төмөрбаатар уургаа тавиад хот орлоо. Тэр 10 өрөөтэй байшин барьж, машин сэлбэн засах үйлдвэр байгуулаад .. малчдын дунд долгион гаргав<sup>8</sup> гэж хэвлэлд бичжээ. Цзинин хотоос Хөх хот ороход машинаар 3 цаг явж байна.

Хөх хот бол ӨМӨЗО-ны төв юм. 6079 ам дөрвөлжин км талбай тай, 1 сая 200 мянган хүн амтай, эртний түүх дурсгалтай холбоотой зүйл арвинтай тэр хотод Ляо улсын (Х зуун) үеийн цамхаг, Мин улсын үеийн ширээт зуу, Их зуу, Лалын шашны төв, Таван суврага зэрэг эртний дурсгалт зүйл олон байна. Хот ерөнхийдөө бараандуу харагдавч өнгө гэрэлтэй орчин үеийн өндөр барилгууд энд тэнд шинээр босч буй нь харагдана.

ӨМӨЗО-ны 40 жилийн ойг угтах ажил өрнөж байгаа юм байна гэж бодогдохоор байна. Хөх хотод «Өвөр Монгол буудал» гэж 16 давхар байшин байна. Эндхийн бүх зүйлийг Гонконгийн тоноглолоор төхөөрөмжилжээ. «Ардын цэцэрлэг», «Мандхайн цэцэрлэг» гэдэг хоёр үндсэн цэцэрлэгтэй Биеийн тамирын ордон нь 5500 хүний багтаамжтай. 1985 онд Өвөр Монголоор дайрч тоглолт хийсэн Улаанбаатарын УАДБЧ-ын жүжигчид тэндэхийн үзэгчидтэй уулзаж урлагийнхаа дээжээс үзүүлж байжээ. Хөх хотоор Бээжин, Хайлаар, Манжуур ба Бугат орох галт тэрэг дайран өнгөрнө. Мөн Бээжин, Хайлаар, Шилийн хот орох нисэх онгоц эндээс өндөрлөг авна.

Хөх хотод хөнгөн ба хүнсний үйлдвэр, хими, машин, төмөрлөгийн үйлдвэр байх ба хэвлэх үйлдвэр цөөнгүй. Иймээс ч ном хэвлэх ажил энд сайн хийгдэж байна. Хөх хот 10 гаруй их, дээд сургууль, 900 гаруй тусгай, ерөнхий боловсролын ба бага сургуультай ажээ. Музей, үзэсгэлэн, соёлын ордон, үлгэрийн танхим гээд соёл үйлчилгээний олон газар байна. Пионерийн ордон нь 11 давхар ажээ. Хот, хөдөө хаана ч явсан ӨМӨЗО-ны нутаг дэвсгэр дээр монгол хүмүүс өөрсдөө эс чадсан ч үр хүүхдээ монгол хэлтэй болгоно гэсэн хандлага их болжээ. Учир нь ХКН, БНХАУ-ын Төрийн зөвлөл хятад биш үндэстний ард түмний талаар явуулсан урьдынхаа алдааг давтахгүй, тухайн үндэстэн Хятадын үндсэн хуульд заасан эрхээ бүрэн эдлэнэ гэж сүүлийн үед их сурталчилж байгаа болохоор ард түмэн түүнд итгэж урам зоригтой иймэрхүү ажил сэдэж байна. Дээр үеэс удам дамжиж хэл, соёл, зан заншлын хувьд Хятадад сүрхий уусч холилдсон харчин, хорчин, түмд ястангууд үр хүүхдэдээ монгол хэл сургах дан монгол сургууль байгуулчихсан, БНМАУ-тай хил залгаж байгаа Өвөр Монгол аймаг хошуудаас Монгол багш нар урин ажиллуулж байх юм. Монгол үндэстний хамгийн нандин эрдэнэ-эх хэлийг сэргээн хөгжүүлэх гэсэн энэ хандлага нэлээд хэдэн жилийн өмнөөс эхэлсэн бөгөөд түүнийг амьдралд хэрэгжүүлэх гэж их л санаа тавьж байгаа нь сэтгэл хөдөлгөж билээ. Гэвч Монгол хэл сураад ямар ирээдүй байна. Дээд сургуульд элсэхэд монгол хэлээр шалгалт авахгүй, орсон хойно монголоор хичээл заахгүй, ажил амьдрал дээр хятад хэлэнд аль хэр юм л гэнэ шүү дээ» гэж эргэлзэх, ухрах явдал байсаар байдаг юм байна. Монгол хэл бичгийг сурч судлах комисс Хөх хотод бүх албан газрын хаягийг эхлээд хуучин монгол үсгээр, дараа нь хятад үсгээр бичих чиглэл өгч, үе үе шалган шаардлага биелүүлээгүй албан газарт мөнгөн торгууль оногдуулж байна. Хөх хотод үндэстний эд хэрэгслийн үйлдвэр

байх бөгөөд тэнд монгол гутал, гөлөм, монгол хутга, эмээлийн хэрэгсэл, дөрөө, гуулин халуун тогоо, гуулин сүүний тогоо, мөнгөн аяга монгол гэр, модон ор гээд олон төрлийн зүйл урлан хийж байна. 1969 оноос хойш эл үйлдвэр дээр дурдсан бүтээгдэхүүнийг 2 сая гаруй ширхэгээр хийж<sup>9</sup> Өвөр Монгол, Төвд, Синьцзян, Сычуань, Хөх нуур, Ганьсу муж оронд илгээж олны талархал хүртэж байгаа гэнэ. Хөх хотод мод тарих ажил сайн зохион байгуулагдаж байна. Хотын хойд талаар үргэлжилсэн Далан хар уулыг хүртэл тав таван жилийн төлөвлөгөөтэй ойжуулж байгааг харахад «олон хүн оломгүй далай» юмдаа гэж бодогдож билээ. Хөх хотын хойд талаар өргөнөөрөө 220 метр, уртаараа 8 км талбайд салхинаас хамгаалах нарсан ой ургуулжээ. Цзинингээс Хөх хот, Хөх хотоос Бугат, Бугатаас Дуншэнь-Чингисийн онгон хүрэхэд ч, Хөх хотоос Бээжин ороход ч мод тарьж ургуулах ажлыг үнэхээр их хийж байгаа нь нүдэнд илхэн харагдаж байлаа. Их зуу аймгийн Эзэн хороо хошууны нутагт элсэн уул манхан дээгүүр хүртэл модыг тариа тарьсан юм шиг суулган ургуулж байгааг үзээд эндхийн хүмүүсийн хөдөлмөрч байдалд бахархаж билээ. 10 жилийн өмнө тэнд очсон хүмүүс «. . хувхай шилийн орой, хужир элсний овоо, хуй салхи боссон, хорвоо дэлхийн бузар» гэж хошигнон ярилцаж байсан бол одоо «. . охью номин оргил, ой модны цэцэрлэг, он цаг нь болохоор, уд торлог цэцэглэнэ»<sup>10</sup> хэмээн магтдаг болжээ.

Аяны замд таарсан бас нэг хот бол Бугат юм. 10 мянга гаруй ам Дөрвөлжин км талбайтай, 1 сая 580 мянган хүн амтай, хүнд аж үйлдвэрийн том хот юм. Тэнд ЗХУ-ын хүч хөрөнгөөр байгуулж өгсөн төмөрлөгийн том комбинат ажилладаг бөгөөд ган хайлуулж, өнгөт металл боловсруулан машин, техник, цэргийн зориулалт бүхий нэлээд зэвсэг, тоног төхөөрөмж үйлдвэрлэдэг болохыг бид эртнээс мэдэх билээ. Нүүрс, шатдаг хий олзворлож, цахилгаан эрчим хүч гаргахаас гадна нэхмэл, чихэр, арьс шир, нэхий боловсруулах, хивс нэхэх, шаазан ваар үйлдвэрлэх хөнгөн үйлдвэр ч олон ажээ. Тоо бүртгэлээс үзвэл Бугат хот том, жижиг нийлсэн 1000 гаруй үйлдвэр аж ахуйн газартай юм байна. Мөн Майдар зуу, Утай зуу зэрэг түүх дурсгалын газар ч тааралдана.

Өвөр Монголын Их зуу аймагт Чингис хааны онгон байдаг бөгөөд одоо түүнийг засан сэлбэх ажил ид өрнөж байна. ӨМӨЗО байгуулагдсаны 40 жилийн ойг 8-р сарын 1-нд тэмдэглэх учир түүнийг угтан ийнхүү сэргээх ажил хийж байгаа ажээ. Чингис хааныг магтах, жилд 3—4 удаа ойг нь тэмдэглэх, тахих, Чингис хааны тухай кино бүтээж нийтийн хүртээл болгох зэрэг ажлыг тогтмол зохион байгуулж байгаагийн цаана «Чингисийн морины туурай хүрсэн газар Хятадын нутаг дэвсгэр» гэсэн өмнөх алдаатай бодлогоо хэвээр хадгалж үлдэх санаархал байж болохыг үгүйсгэх аргагүй юм.

Аяны замд олон хүмүүстэй уулзаж санаа бодлоо хуваалцаж үзсэн. Хүмүүсийн санаа сэтгэл нэг үеэ бодвол өөдрөг «ирээдүй маань сайн сайхан байгаасай, төрийн бодлогод хувиралт бага гараасай, эх нутагтаа амгалан тайван амьдарч, өрх гэртээ аз жаргалтай сууж, эх орон доо чадах чинээгээрээ хүчээ өгч, хойч ирээдүйдээ юм бүтээж үлдээх юмсан» гэсэн хүмүүс л олон байна. Гэхдээ ирээдүйдээ тэд бат итгэлтэй болж байна гэж хэлэхэд өнөөдөр эртдэнэ гэж надад бодогдсон.

9 «Өвөр Монголын залуучууд» Хөх хот, 1984. № 7 23-р тал

10 «Алтан ганьдир» сэтгүүл, Дуншэнь, 1987, № 1, 25-р тал

Яагаад гэвэл урьд өмнө явсан удаа дараагийн улс төрийн кампаний шарх, сорви эдгээгүй, хүмүүсийн айх явдал бүрэн арилаагүй байна. Цаашид хэрхэхийг өнөөгийн улс төрийн бодлоготнууд харуулах болохоор ард түмэн түүнийг л хүлээж, ажиглаж явна даа гэж санагдлаа.

**МОНГОЛД БАЙГАА МАНЖ  
ХЭРЭГЛЭГДЭХҮҮНИЙ  
УРЬДЧИЛСАН СУДАЛГААНЫ  
ТОВЧ ТОЙМ**

**А. Дашдэмбэрэл**

Төв Азийн нүүдэлчин улс түмний дунд манж нарын түүх соёл томоохон байр эзэлдэг юм. Манж нарын гарал үүслийн талаар Хятадын болон бусад сурвалж бичигт дурдсанаар Хятадын Шань инь улс мөхөж, Чжоу улс байгуулагдах үе буюу МЭӨ 1100-аад оны үед одоогийн Хятадын зүүн хойт хэсэгт оршин сууж байсан Су шэнь нараас гаралтай гэж үзэж байна<sup>1</sup>.

Эрдэмтдийн судлан шинжилснээр манж нарын өвөг дээдсийн анхны төр улс болох Бохай<sup>2</sup>-н үеэс манж Чин улсын мөхөх хүртэл 1000 гаруй жилийн түүхэнд Манжийн язгууртнууд газар нутгаа өргөтгөж, эд баялаг, эрх ямбаа нэмэгдүүлэхийн төлөө үргэлжийн дайн байлдаан хийж, энгийн номхон ард иргэдийн цусыг урсгаж байсан мэдээ, баримт түүх шастир, бичиг зохиолд олонтаа бичигдсэн байх юм. Энэ дайн байлдааны эцсийн зорилго нь бусад улс орныг өөрийн хараат болгож, байнга алба бариулан, эд баялагийг нь цөлмөн хоосолж, цэрэг дайны үед тогтоосон хэмжээний цэрэг, зэр зэвсгийг гаргуулж байх явдал байлаа. Монгол, Манжийн харилцааны түүх ч мөн үүнийг гэрчилж байна. Монголд Манж нарын түүх соёлыг хэдий үеэс судалж байсныг архивийн материал, түүхийн сурвалж бичиг зохиолуудад тулгуурлан нэгтгэж, товч тоймыг гаргах зорилго тавьж байна. Марксист ленинист түүхийн шинжлэх ухаан аливаа ард түмний тодорхой түүхийг ерөнхий онолын зүй тогтлын үүднээс судлахын зэрэгцээгээр бас тухайн орны нийгмийн аль нэг байгууллын хөгжилд тохиолдож байсан түүхэн үйл явдал, үзэгдлийн онцлогийг илрүүлдэг.

Монголд Манжийн түүх, соёлыг судалж байсныг түүхийн сурвалж материалаас шүүрдэн авч үзвэл: XIV зуунаас 1921 оны ардын хувьсгал, 1921 оноос хойших үе гэж хоёр үе шат болгон үечилж байна.

Монголын хамгийн сүүлчийн хаан Тогоонтөмөр 1343 онд зарлиг буулгаж, Ляо Цзинь, Сүн гурван төрийн түүх зохиох нөр их ажлын ерөнхий редактороор эрдэмтэн тогтохыг тохоон томилжээ. Тогтох уул ажлыг зарлигийн ёсоор хугацаанд нь хийж дуусгасан байна. Тогтох ба Мэргэд аймгийн Бухулай жанжны удмын Мазартайн хүү монгол хүн байжээ. Тухайн үеийн Монголын сурвалжтаны дотроос хамгийн олон боть ном уншиж зохиосон эрдэм номд төгс боловсорсон хүн

1 Алтан улсын судар. 1 дэвтэр, гар бичмэл. Пян Бо Манж үндэстэн. Бээжин 1985. 10-р-тал

2 Мөн тэнд